



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө данснаас хасах, орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.2, 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний статистикийн хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 33,469,742.00 (гучин гурван сая дөрвөн зуун жаран есөн мянга долоон зуун дөчин хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх, ашиглах хугацаа үнийг шинэчлэн тогтоож орон нутгийн өмч (Ихтамир сумын Засаг даргын Тамгын газар)-д бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиньг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 05 дугаар сарын 5 ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСНААС ХАСЧ,  
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл/ төгрөг/	Цаашид ашиглах жил /тоогоор/ /төгрөг/		Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/
1	Суудлын автомашин TOYOTO LAND CRUISER J100 JTECJ09J905508570, улсын дугаар 4419 УБР	2002/2003	325,000	33,469,742.00		2	10,000,000.00
				33,469,742.00			10,000,000.00
	НИЙТ ҮНЭ			(гучин гурван сая дөрвөн зуун жаран есөн мянга долоон зуун дөчин хоёр төгрөг)			(арван сая )